

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18-19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	21-23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24-25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА

2024.02.23 № 00А-2024/03/НА-СТА-ТН/3
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 160,804.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5-д заасантай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус эмнэлэг нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,596,992.7 мянган төгрөгийн сантехникийн засварын ажил, ЭМЯ-аас 198,096.4 мянган төгрөгийн Nissan Patrol Y маркийн эмнэлгийн зориулалттай автомашин, 30,000.0 мянган төгрөгийн Toyota Hiace маркийн түргэн тусламжийн автомашиныг хүлээн авч, орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн мөрдөж буй 2010 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын

гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

Бараа материалын дансанд Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад ЭМЯ, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн нийт 60,697.5 мянган төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл бүртгэлтэй байна. Эдгээр бараа материалын ашиглалтын хугацаа дуусаж, хадгалалтын нөхцөл алдагдаж ашиглагдахгүй болох эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	533,521,592.32	846,322,547.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,383,958.18	187,536,438.53
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,383,958.18	187,536,438.53
3121	Төгрөг	10,383,958.18	187,536,438.53
31211	Төрийн сангийн харилцах	10,383,958.18	187,536,438.53
33	АВЛАГА	00.00	118,954,411.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	118,954,411.00
335	Бусад авлага	00.00	3,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	523,137,634.14	539,831,698.15
351	Түүхий эд материал	494,799,617.64	506,916,954.15
35110	Тусгай зориулалттай материал	47,634,400.00	47,634,400.00
35130	Эм боох материал	447,165,217.64	459,282,554.15
354	Хангамжийн материал	28,338,016.50	32,914,744.00
35410	Бичиг хэргийн материал	8,120,150.00	6,372,740.00
35420	Аж ахуйн материал	6,006,248.00	7,527,108.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	8,229,320.00
35440	Түлш, шатах тослох материал	1,376,000.00	4,680,000.00
35450	Барилгын засварын материал	1,501,800.00	1,660,600.00
35460	Хүнсний материал	11,333,818.50	4,444,976.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,938,696,489.59	19,065,849,670.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,938,696,489.59	19,065,849,670.38
392	Биет хөрөнгө	17,514,148,489.59	18,642,921,670.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,922,542,856.00	10,519,535,569.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-632,155,937.69	-981,319,048.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	366,044,085.00	549,383,623.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,118,442.02	-98,217,783.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,425,511,353.87	10,917,286,301.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,503,419,591.88	-3,112,437,724.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,160,044,625.73	1,176,753,125.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-129,382,866.13	-331,686,958.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,578,400.00	4,578,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-495,993.29	-953,833.25
393	Биет бус хөрөнгө	424,548,000.00	422,928,000.00
39301	Програм хангамж	11,815,000.00	11,815,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,715,000.00	-5,335,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	416,448,000.00	416,448,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,472,218,081.91	19,912,172,218.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	506,278,071.14	1,655,438,662.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	506,278,071.14	1,655,438,662.75

413	Өглөг	506,278,071.14	1,655,438,662.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	100,360,171.97
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	495,540,755.14	1,476,231,036.78
4136	Бусад өглөг	10,737,316.00	78,847,454.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,737,316.00	78,847,454.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,965,940,010.77	18,256,733,555.31
51	Засгийн газрын хувь оролцоо	17,965,940,010.77	18,256,733,555.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,303,619,352.00	3,303,619,352.00
51101	Өмч: - төрийн	3,303,619,352.00	3,303,619,352.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,302,542,920.29	7,595,806,524.83
51210	Өмнөх үеийн үр дүн	7,302,542,920.29	7,305,012,980.29
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	290,793,544.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,359,777,738.48	7,357,307,678.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,472,218,081.91	19,912,172,218.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,080,436,575.90	14,305,544,761.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,412,542,032.90	4,264,992,234.02
120	Нийтлэг татварын бус орлого	2,101,316,705.25	961,689,635.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,101,316,705.25	961,689,635.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,564,296.00	338,257,857.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,366,179,587.00	427,959,324.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	426,572,822.25	195,472,454.82
122	Тусламжийн орлого	5,311,225,327.65	3,303,302,598.20
122001	Хандив тусламж /дотоод/	5,311,225,327.65	3,303,302,598.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,667,894,543.00	10,040,552,527.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,623,797,640.00	10,040,552,527.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,623,797,640.00	10,040,552,527.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,018,986,954.24	13,683,603,017.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,018,986,954.24	13,683,603,017.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,984,074,897.24	13,636,774,217.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,453,828,824.94	6,673,023,831.03
210101	Үндсэн цалин	3,252,471,722.16	3,674,044,256.06
210102	Нэмэгдэл	1,892,981,498.18	2,288,446,735.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	177,357,539.48	168,896,442.86
210104	Урамшуулал	131,018,065.12	541,636,396.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	694,683,833.38	833,579,322.26
210201	Тэтгэврийн даатгал	482,260,000.62	581,940,031.96

210202	Тэтгэмжийн даатгал	55,627,143.73	69,506,242.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,849,755.55	57,175,028.09
210204	Ажилгүйдлийн даатгал	9,457,718.60	11,249,084.01
210205	Эрүүл мэндийн даатгал	103,489,214.88	113,708,935.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,005,323,470.00	927,461,255.70
210301	Гэрэл, цахилгаан	160,314,730.00	161,427,723.30
210302	Түлш, халаалт	482,091,768.00	456,259,858.00
210303	Цэвэр, бохир ус	362,916,972.00	309,773,674.40
2104	Хангамж, бараа материалын зардал	199,843,720.20	239,897,916.16
210401	Бичиг хэрэг	22,661,163.00	26,410,950.00
210402	Тээвэр, шатахуун	81,007,882.79	92,897,136.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,514,404.41	19,180,050.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,950,000.00	10,385,985.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,710,270.00	91,023,795.00
2105	Нормативт зардал	2,416,625,687.84	2,562,231,104.73
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,128,337,288.81	2,276,060,855.23
210502	Хоол, хүнс	261,403,449.03	242,161,049.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,884,950.00	44,009,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,326,530.00	87,284,750.00
210604	Урсгал засвар	58,326,530.00	87,284,750.00
2107	Томилолт, зочны зардал	14,988,600.00	20,115,200.00
210702	Дотоод албан томилолт	14,988,600.00	20,115,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,971,870.00	69,598,342.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,777,470.00	47,494,370.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,408,500.00	1,735,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	388,800.00	525,262.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	382,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,942,000.00	10,495,000.00
210807	Газрын төлбөр	199,980.00	400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,609,120.00	8,783,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,083,482,360.88	2,223,582,495.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,806,600.00	17,163,078.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,066,424,760.88	2,206,419,417.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,912,057.00	46,828,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,912,057.00	46,828,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,912,057.00	46,828,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,061,449,621.66	621,941,743.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	180,160,651.60	331,148,198.69
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	180,160,651.60	331,148,198.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-180,160,651.60	-331,148,198.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,881,288,970.06	290,793,544.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,842,193,472.10	10,676,737,297.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,674,743,883.00	752,139,181.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,674,743,883.00	752,139,181.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,674,743,883.00	752,139,181.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,055,596.00	327,179,857.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,367,688,287.00	424,959,324.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,167,449,589.10	9,924,598,116.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,123,352,686.10	9,924,598,116.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,123,352,686.10	9,924,598,116.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,866,908,491.19	10,469,994,816.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,866,908,491.19	10,469,994,816.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,848,746,250.19	10,428,880,416.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,627,024,170.63	6,642,842,719.71
210101	Үндсэн цалин	3,380,500,079.41	3,548,236,657.58
210102	Нэмэгдэл	1,938,131,136.36	2,384,073,222.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	177,354,539.74	168,896,443.16
210104	Урамшуулал	131,038,415.12	541,636,396.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	695,547,966.96	764,125,261.61
210201	Тэтгэврийн даатгал	482,260,000.62	560,162,950.74
210202	Тэтгэмжийн даатгал	55,627,143.73	56,166,992.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,849,755.55	46,736,828.31
210204	Ажилгүйдлийн даатгал	10,321,852.18	9,101,130.00
210205	Эрүүл мэндийн даатгал	103,489,214.88	91,957,359.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,010,035,970.00	813,458,629.30
210301	Гэрэл, цахилгаан	160,314,730.00	161,427,723.30
210302	Түлш, халаалт	482,791,768.00	329,877,964.00
210303	Цэвэр, бохир ус	366,929,472.00	322,152,942.00
2104	Хангамж, бараа материалын зардал	192,513,375.20	186,155,321.89
210401	Бичиг хэрэг	23,189,853.00	11,132,550.00
210402	Тээвэр, шатахуун	81,352,900.00	96,483,536.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,323,782.20	19,019,542.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,045,300.00	11,075,985.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,601,540.00	48,443,708.00
2105	Нормативт зардал	3,160,304,052.40	1,841,365,576.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,907,397,143.40	1,600,665,240.64
210502	Хоол, хүнс	236,199,709.00	205,984,735.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,707,200.00	34,715,600.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,469,065.00	73,974,305.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,219,800.00	8,655,005.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,265,000.00	8,349,000.00
210604	Урсгал засвар	59,984,265.00	56,970,300.00
2107	Томилолт, зочны зардал	14,988,600.00	19,125,800.00
210702	Дотоод албан томилолт	14,988,600.00	19,125,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,464,550.00	69,171,048.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,734,470.00	43,540,386.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,408,500.00	1,735,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	388,800.00	525,262.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,942,000.00	10,033,000.00
210807	Газрын төлбөр	199,980.00	400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,306,800.00	12,772,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,398,500.00	18,661,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,813,500.00	18,661,755.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,162,241.00	41,114,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,162,241.00	41,114,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,162,241.00	41,114,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-24,715,019.09	206,742,480.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,811,900.00	29,590,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,811,900.00	29,590,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,811,900.00	29,590,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,811,900.00	29,590,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-42,811,900.00	-29,590,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-67,526,919.09	177,152,480.35
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,910,877.27	10,383,958.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,383,958.18	187,536,438.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,422,036,914.47	-814,488,479.45	9,911,167,787.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,303,619,352.00	7,422,036,914.47	-814,488,479.45	9,911,167,787.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,031,666,743.74	1,031,666,743.74
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,359,777,738.48	7,302,542,920.29	17,965,940,010.77
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,359,777,738.48	7,302,542,920.29	17,965,940,010.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,470,060.00	2,470,060.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,303,619,352.00	7,359,777,738.48	7,305,012,980.29	17,968,410,070.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,470,060.00	00.00	-2,470,060.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	290,793,544.54	290,793,544.54
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	7,595,806,524.83	18,256,733,555.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,061,824,900.00	10,499,584,816.65	562,240,083.35	94.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,061,824,900.00	10,499,584,816.65	562,240,083.35	94.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,020,644,900.00	10,458,470,416.65	562,174,483.35	94.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,892,729,200.00	6,642,842,719.71	249,886,480.29	96.37
210101	Үндсэн цалин	3,967,878,000.00	3,548,236,657.58	419,641,342.42	89.42
210102	Нэмэгдэл	2,204,913,400.00	2,384,073,222.75	-179,159,822.75	108.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	224,768,000.00	168,896,443.16	55,871,556.84	75.14
210104	Урамшуулал	495,169,800.00	541,636,396.22	-46,466,596.22	109.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	842,513,600.00	764,125,261.61	78,388,338.39	90.70
210201	Тэтгэврийн даатгал	629,572,400.00	560,162,950.74	69,409,449.26	88.98
210202	Тэтгэмжийн даатгал	57,297,300.00	56,166,992.71	1,130,307.29	98.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,241,500.00	46,736,828.31	-2,495,328.31	105.64
210204	Ажилгүйдлийн даатгал	10,073,000.00	9,101,130.00	971,870.00	90.35
210205	Эрүүл мэндийн даатгал	101,329,400.00	91,957,359.85	9,372,040.15	90.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	971,858,100.00	813,458,629.30	158,399,470.70	83.70
210301	Гэрэл, цахилгаан	156,232,900.00	161,427,723.30	-5,194,823.30	103.33
210302	Түлш, халаалт	446,080,200.00	329,877,964.00	116,202,236.00	73.95
210303	Цэвэр, бохир ус	369,545,000.00	322,152,942.00	47,392,058.00	87.18
2104	Хангамж, бараа материалын зардал	187,545,700.00	186,155,321.89	1,390,378.11	99.26
210401	Бичиг хэрэг	14,856,200.00	11,132,550.00	3,723,650.00	74.94
210402	Тээвэр, шатахуун	91,080,600.00	96,483,536.14	-5,402,936.14	105.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,130,000.00	19,019,542.75	-3,889,542.75	125.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,395,200.00	11,075,985.00	1,319,215.00	89.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,083,700.00	48,443,708.00	5,639,992.00	89.57
2105	Нормативт зардал	1,861,413,500.00	1,841,365,576.14	20,047,923.86	98.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,601,029,600.00	1,600,665,240.64	364,359.36	99.98
210502	Хоол, хүнс	219,883,900.00	205,984,735.50	13,899,164.50	93.68
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,500,000.00	34,715,600.00	5,784,400.00	85.72

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,917,300.00	103,564,305.00	3,352,995.00	96.86
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,766,000.00	34,608,805.00	157,195.00	99.55
210602	Тавилга	3,636,200.00	3,636,200.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,500,000.00	8,349,000.00	3,151,000.00	72.60
210604	Урсгал засвар	57,015,100.00	56,970,300.00	44,800.00	99.92
2107	Томилолт, зочны зардал				
		19,140,000.00	19,125,800.00	14,200.00	99.93
210702	Дотоод албан томилолт	19,140,000.00	19,125,800.00	14,200.00	99.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,527,500.00	69,171,048.00	18,356,452.00	79.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,549,200.00	43,540,386.00	8,814.00	99.98
210803	Даатгалын үйлчилгээ	2,411,700.00	1,735,350.00	676,350.00	71.96
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,509,200.00	525,262.00	1,983,938.00	20.93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,960,000.00	165,000.00	2,795,000.00	5.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,699,000.00	10,033,000.00	7,666,000.00	56.69
210807	Газрын төлбөр	400,000.00	400,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,998,400.00	12,772,050.00	5,226,350.00	70.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,000,000.00	18661755.00	32,338,245.00	36.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,000,000.00	18,661,755.00	32,338,245.00	36.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41180000.00	41114400.00	65,600.00	99.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,180,000.00	41,114,400.00	65,600.00	99.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,180,000.00	41,114,400.00	65,600.00	99.84
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,061,824,900.00	10,676,737,297.00	385,087,603.00	96.52
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,919,975,241.82	9,924,598,116.00	-4,622,874.18	100.05
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,919,975,241.82	9,924,598,116.00	-4,622,874.18	100.05
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,141,849,658.18	752,139,181.00	389,710,477.18	65.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	659,304,500.00	327,179,857.00	332,124,643.00	49.62

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	472,161,200.00	424,959,324.00	47,201,876.00	90.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,383,958.18		10,383,958.18	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	323.00	283.00	40.00	87.62
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	257	226	31	87.94
620003	Үйлчлэх ажилтан	65	56	9	86.15

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг /цаашид Аймгийн Нэгдсэн эмнэлэг гэх/ нь “Иргэдийн сонголт, эмчилгээний нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг мэдлэгтэй, чадвартай, сэтгэлтэй, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ээлтэй, эрсдэлгүй, аюулгүй орчинд үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ,
- Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж,
- Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ,
- Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ,
- Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргын журмыг шинэчлэн баталсан,
- 2023 оны 11 сарын 17-ны өдрийн ЭМДҮЗ-ийн 10 дугаар тогтоолоор “Багц төлбөрийн хэмжээ”-ний журам баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2010 онд боловсруулагдсан Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,439,954.2 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,383.90	187,536.40	177,152.50
Авлага	-	118,954.40	118,954.40
Бараа материал	523,137.60	539,831.70	16,694.10
Үндсэн хөрөнгө	17,938,696.50	19,065,849.70	1,127,153.20
Нийт хөрөнгө	18,472,218.00	19,912,172.20	1,439,954.20
Өр төлбөр	506,278.00	1,655,438.60	1,149,160.60
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,965,940.00	18,256,733.60	290,793.60
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	18,472,218.00	19,912,172.20	1,439,954.20

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 187,536.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эцэст ЭМЯ-аас өр төлбөр барагдуулахад зориулж нэмэлт санхүүжилт олгосон боловч төрийн сангийн гүйлгээ хаагдсанаас,
- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 118,954.4 мянган төгрөгийн, түрээсийн орлогын 3,000.0 авлага тус тус тайлагнагдсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,065,849.7 мянган төгрөг болж 1,127,153.2 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,596,992.7 мянган төгрөгийн сантехникийн засварын ажлыг хүлээн авснаас голлон шалтгаалсан,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,655,438.6 мянган төгрөг болж 1,149,160.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үзүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-аас дутуу төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 12,015,643.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 605,485.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 232,193.4 мянган төгрөг зэрэг нийт 12,853,321.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 80,606.2 мянган төгрөгөөр бууруулж, 12,772,715.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 132,549.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 59,000.0 мянган төгрөгөөр бууруулж,
- Хангамж, бараа материалын зардлыг 58,973.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 51,970.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 1,710,890.7 мянган төгрөгөөр бууруулсан тодотгол, зохицуулалт хийж, 11,061,824.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Нормативт зардлыг 1,644,531.3 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 412,180.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 77,082.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж,
- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 376,069.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,061,824.9 мянган төгрөгийн төсөв баталж, ЭМДС-аас 9,919,975.2 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,131,465.7 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр ЭМДС-аас 9,924,598.1 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 352,139.2 мянган төгрөг, ЭМЯ-аас /улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт/ 400,000.0 мянган төгрөгийг авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,499,584.8 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 379,326.5 мянган төгрөгөөр тасарснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,616,876.50	10,238,087.50	378,789.00	96.43
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	41,180.00	41,114.40	65.60	99.84
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	403,768.40	220,382.90	183,385.50	54.58
	Дүн	11,061,824.90	10,499,584.80	562,240.10	94.92

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130020402 дугаар дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

/мянган төгрөг/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	2,548,570.2	2,213,645.2	НТШ
2	Түргэн тусламжийн автомашины шатахуун, тослох материал нийлүүлэх	106,303.7	102,660.4	НТШ
3	Хоол хүнсний материал нийлүүлэх	312,020.0	219,883.9	НТШ
	Нийт дүн	2,966,893.9	2,536,189.5	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулан, шалгарсан дараах аж ахуйн нэгжүүдтэй бараа материал нийлүүлэх гэрээг байгуулан ажилласан байна.

Ази фарм, Агниста фарм, Айвико хэлт кэйр, Их шүүдэргэнэ, Медиконт, Медклийн, Монбиофарм, Монгол эм импекс, Монос трейд, Монфа трейд, Мөнхийн тун, Сетунари, Сүвэн уул, Тэгш анар, Лайфтроник, Антегин, Энто ХХК зэрэг компаниудтай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ, Сод Монгол ХХК-тай шатахуун, тослох материал худалдан авах гэрээ, Сэлэнгэ баян уул, Алтан тариа, Галил-Этоос, Цахим ертөнц, Куку агро ХХК-аас хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс ерөнхий нэршлийн 161 нэр төрлийн 433,506.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 16,080436.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 160,804.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Шатахууны зардлыг хэмнэх зорилгоор автомашинуудад байршил тогтоогч суурилуулсан,*
- *Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,*

- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээлбэл зохиох 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 332.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 82,086.8 мянган төгрөгийн албан шаардлага, 43,299.5 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөнөөс албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	332.9	1	332.9	100.0
Албан шаардлага	3	82,086.8	1		33.3

/мянган төгрөгөөр/

Зөвлөмж	1	43,299.5	1	43,299.5	100.0
Нийт дүн	5	125,719.2	3	43,632.4	77.6

Өмнөх аудитаар өгсөн төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны зардлаас санхүүжүүлсэн зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу ахлах нягтлан бодогч Ц.Энх-Оюунд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит болон дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуустал хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох 758,714.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/323, 2021 оны А/214 дугаар захирамжуудаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан боловч уг захирамжууд нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9.2, 17.9.3, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.10 дахь заалтуудыг зөрчсөн тул зөвлөл үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо бүрдээгүй байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийг байгуулаагүй байгаа нь эмнэлгийн тухай жилийн төсвийг хэлэлцэж батлах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, эмнэлгийн тухай жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих ажлууд хийгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 385,337.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Цайны газрын түрээсийн орлогыг 3,000.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгэж, тайлагнаагүй,
2. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 305,958.3 мянган төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан,
3. Үндсэн хөрөнгийн тайланд 43,165.5 мянган төгрөгийн өртөгтэй 24 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацааг хасах утгаар илэрхийлж тайлагнасан,
4. Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 33,213.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга, эд хогшлын дансанд бүртгэсэн.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар.”-ын 4.35 дахь “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Дт. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, Кт. Хуримтлагдсан элэгдэл” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 185,660.4 мянган төгрөгийн зөрчил² илэрч албан шаардлага хүргүүлэн, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр **164,722.6** мянган төгрөгийн дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- 2022 оны 3, 4-р улирлын үр дүнгийн урамшуулал цалин **128,786.4** мянган төгрөгийг тухайн жилийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаж, тайлагнаагүй атал 2023 оны төсвөөс төлж барагдуулсан,
- Цалин хэлс болон нэмэгдэл урамшлын зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 32,017.4 мянган төгрөгийг, хоолны зардлаас 1 удаагийн тэтгэмж урамшуулалд 3,918.8 мянган төгрөгийг зэрэг нийт 35,936.2 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3: бүх өр төлбөр...”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, аелага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу ахлах нягтлан бодогч Ц.Энх-Оюунд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу **19,140.0** мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Ажил гүйцэтгэсэн тайлан, хүлээн авсан актгүйгээр эмнэлгийн хашаанд тарьсан мод бутыг тайрах, тэгшлэх, зөөж хаях ажлыг гүйцэтгүүлсэн гэж иргэн Б.Мөнхбаярт 7,640.0 мянган төгрөг шилжүүлсэн байна,
- Хийсэн ажлын тайлан, үр дүнг үнэлэлгүйгээр ажлын бүтээмж, үр дүнд суурилсан гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хөлсөнд “Эрүүл амьдралыг иргэн бүрт” ТББ-д 6,000.0 мянган төгрөг шилжүүлсэн,
- Сургалтын гүйцэтгэл, үр дүнгийн тайлангүйгээр эмнэлгийн ажиллагсдын яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах “Цаг бол амьдрал” сэдэвт сургалтын цай, хоолны зардалд 5,500.0 мянган төгрөг зарцуулсан гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах, хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

4. ЭМДС-аас авах санхүүжилт болон өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг түүвэрлэн шалгахад 1,020.0 мянган төгрөгийн ор хоногийн төлбөр болон 777.8 мянган төгрөгийн өндөр өртөгт шинжилгээ, үйлчилгээний төлбөрийг ЭМДС-аас дутуу нэхэмжилсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтад үндэслэн төлбөр тооцоог хянаж, өөрийн орлого болон санхүүжилтийг үнэн зөв бүртгэн, бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 -т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана.” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Үйлчилгээний төлбөрийг дутуу нэхэмжилж, орлого дутуу төвлөрүүлсэн	1	1,797.8		1	1,797.8		
НББББ нь хууль тогтоомж, бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт нийцээгүй.	1	-				1	
Дүн	4	185,660.4		3	185,660.4	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						

437742367
МРОА/095 903435

/Мянган төгрөгөөр/